АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын нэр: ***Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн /Plant.mofa.gov.mn/ цахим системд таримал ургамлын сортын бүртгэл хөтлөх таримал тус бүрээр үр үрслэг суулгац үйлдвэрлэгч борлуулагчдын бүртгэх модуль хөгжүүлэлт***

Төсөвт өртөг: **50,000,000.0 /тавин/ сая төгрөг**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн /Plant.mofa.gov.mn/ цахим системд таримал ургамлын сортын бүртгэл хөтлөх таримал тус бүрээр үр үрслэг суулгац үйлдвэрлэгч борлуулагчдын бүртгэх модуль хөгжүүлэлтийн хүрээнд таримал ургамалын үр сортын үндэсний нэгдсэн бүртгэлийг үүсгэх, ангилан хардаг, зөвшөөрөл олгодог боломжтой болгох.з

1. Үр, Сортын бүтээгчийн эрх авах хүсэлт гаргах, хүсэлтэд шүүлт хийх боломжтой байх
2. Үр, Сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн болохын тогтоодог боломжтой байх
3. Хамгаалагдсан сортын бүтээгчийн эрх олгох, нийтэд мэдээлэхтэй боломжтой байх
4. Үр үржүүлэг, сортын үйлдвэрлэл, худалдан борлуулах, импортлох мэдээллийг бүртгэх боломжтой байх
5. Сортыг сорих, сортын үндэсний бүртгэлд бүртгэх боломжтой байх
6. Бүртгэлээс хасах журмуудын дагуу баталгаажуулах системийг хөгжүүлнэ.
7. Таримал ургамлын шинэ сортыг нэрлэх хөгжүүлэлт хийх
8. Үндэсний үр, сортын бүртгэлд бүртгэгдсэн тухай цахим гэрчилгээг хэвлэн авах нөхцлийг програмчлах, хөгжүүлэлт хийх
9. Агуулах зоорийн бүртгэл мэдээлэл, хадгалах болон хадгалж байгаа бүтээгдэхүүний мэдээлэл оруулах системийн хөгжүүлэлт хийх
10. Хэрэглэгч, ашиглагч байгууллага ашиглах тоон мэдээллийг татах, ашиглахад хялбар байх хөгжүүлэлт хийх.
11. ОУ-ын сортын бүртгэлээс сортын мэдээлэл автоматаар татах боломжийг бүрдүүлэх
12. Шинэ сортын бүртгэлтэй холбоотой мэдээлэлийг хариуцсан мэргэжилтэн системд бүртгэх, засварлах өөрчлөлт оруулах боломжтой хөгжүүлэлт хийх
13. Сортын нарийвчилсан тайлан гаргах хөгжүүлэлт хийх

2. Нүүр хуудасны харагдах загварт тавигдах шаардлага

1. Толгойн хэсэгт яамны лого, системийн нэр, үндсэн цэс, нэврэх хэсэг, регистрийн дугаараар лавлагаа шалгах хэсэг байна.

2. Дашборд хэсэгт таримлын төрөл, сортын нэр, батлагдсан хугацаа, сорт батлуулсан байгууллага тоон мэдээлэл, хайлтын хэсэг байна.

3. Хөлийн хэсэгт систем ашиглах заавар, холбоо барих мэдээллийн хэсэг байна.

4. Программ ашиглах зааврааас гадна сортын бүртгэл тус бүрт нь шинээр авах, сунгуулахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг ил байлгах, текстэн танилцуулга оруулах.

3. Системийн загварт тавигдах шаардлага

1. Таримал ургамлын үр сортын тухай хуулийн нэр томъёо, түүний дагалдах журмын хүрээнд тавигдах шаардлагын дагуу ялгах, хайх боломжтой болгох.

2. Батлагдсан, дэвшигдсэн, үйлдвэрлэл ашиглагдаж байгаа, туршигдаж буй таримал сортын төрөл тус бүрээр оруулдаг болгох.

3. Таримал ургамлын үр, сортын мэдээллийн график үзүүлэлтийн өнгийг тохируулах, хэрэглэгч ашиглахад хялбар байх

4. Аж ахуйн нэгжийн хандалт, буцаалт, нөхөн бүрдүүлэлтийн түүхийг татаж авах, хэвлэх боломжтой болгох.

5. Аж ахуйн нэгж, иргэн системд нэг хүсэлтийг олон удаа засах боломжтой болгож, заавал оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсны дараа баталгаажуулж, хүсэлтийг илгээх боломжтой болгох, баталгаажуулаад хүсэлт илгээсний дараа шийдвэрлэх хүртэл дахин хүсэлт илгээх, засварлах боломжгүй болгох.

6. Цахим системд илгээсэн хүсэлтийг дараалал, хугацааг нарийвчлан харуулах тохируулагатай болгох.

4. Системд шинээр хөгжүүлэлтийн үндсэн ажлын шаардлага

1. Үндсэн систем (ХУР)-ээс шууд татах боломжтой /Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Иргэний үнэмлэх, дипломын лавлагаа, оюуны өмчийн патент.... гэх мэт/ мэдээллийг цаасаар шаардахгүй болгох

2. Хэрэглэгчдэд үр, сортын үндэсний бүртгэлд бүртэгдсэн эсэх лавлагааг QR кодтой өгдөг болгох

3. Удирдлагын болон ажлын хэсгийн гишүүдийн бүлгийг цахим материалтай танилцаад санал тэмдэглэж санал өгөх, ажлын хэсгийн гишүүд тоон гарын үсгээр хандах, тоон гарын үсэг зурах боломжийг бүрдүүлэх.

5. Системийн хөгжүүлэлтэд тавигдах шаарлага

№	Гүйцэтгүүлэх ажлын төрөл	Гүйцэтгүүлэх ажилд тавигдах шаардлага	Гүйцэтгэх хугацаа
1	Системийн хэвийн ажиллагааг хангах үйлчилгээ	1. Системийн ажиллагаатай холбоотой гарсан алдаа, доголдлыг илрүүлэх, засварлах, тохиргоог тухай бүр хийх 2. Системийн хэвийн ажиллааг хангаж, засварын хүсэлтийг тухай бүр хийх 3. Хур, Дан, бусад системтэй холбогдох service гаргах боломжийг тухай бүр бүрдүүлэх	Гэрээ цаашид үргэлжлэх хугацаанд
2	Системийн хөгжүүлэлтийн үйлчилгээ	1. Хэрэглэгч ашиглахад маш хялбар, энгийн, ойлгомжтой байх 2. Цаашид хөгжүүлэхэд бүрэн боломжтой байх 3. Системийн ажиллагаатай холбоотой гарсан алдаа, доголдлыг илрүүлэх, засварлах, тохиргоог тухай бүр хийх боломжтой байх 4. Системийн хэвийн ажиллагааг хангаж, засварын хүсэлтийг тухай бүр хийх 5. Агуулах зоорийн бүртгэл мэдээлэл, хадгалах болон хадгалж байгаа бүтээгдэхүүний мэдээлэл оруулах боломжтой байх. 6. Үндэсний сортын бүртгэлд бүртгэгдсэн тухай гэрчилгээг хэвлэн авах нөхцлийг програмчлах, хөгжүүлэлт хийх 7. Шинэ сортын бүртгэлтэй холбоотой мэдээлэлийг хариуцсан мэргэжилтэн системд бүртгэх, засварлах өөрчлөлт оруулах боломжтой болгох 8. Админ зөвшөөрлийн эрх олгох, цэсийн утгуудыг засварлах боломжтой болгох, 9. Ажлын хэсэг буюу материалтай танилцаж буй албан тушаалтнууд (Сайдын тушаалд гарын үсэг зурж буй хэрэглэгчид) санал өгдөг болгох. 10. Системийн хэрэглэгчийн үйлдлүүдийг бүртгэх лог /log/-ийн хэсэгтэй болгох.	Гэрээ цаашид үргэлжлэх хугацаанд
3	Зөвлөх үйлчилгээ	1. Системийг ашиглах, хэрэглэхтэй	Гэрээ цаашид

		холбоотой арга зүйн зөвлөгөө өгөх 2. Системийг ашиглах заавар, гарын авлагыг шинэчлэх 3. Системийг сайжруулах санал, зөвлөмж өгөх 4. Хүний оролцоо багатайгаар автоматжуулах, ухаалаг болгох санал, зөвлөмж өгөх	үргэлжлэх хугацаанд
4	Мэргэшүүлэх сургалтын үйлчилгээ	1. Систем ашиглагч өөрчлөгдсөн тохиолдолд admin болон хэрэглэгчийн түвшний сургалтуудыг тогтмол зохион байгуулах	Гэрээ цаашид үргэлжлэх хугацаанд

5. Ажлын үргэлжлэх хугацаа

ХХААХҮЯам нь сонгогдсон зөвлөхтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажил үргэлжлэх хугацаа 4 сараас хэтрэхгүй байна.

6. Тайлагналт

Зөвлөх нь энэхүү даалгаврыг гүйцэтгэх хугацуаанд ажлын үр дүнгээ ХХААХҮЯ-нд тайлагнах ба дараах тайлангуудыг ирүүлнэ.

- Эхлэлтийн тайлан
- Эцсийн тайлан

7. Программ хангамжийн баталгаат хугацаа, засвар үйлчилгээ

Модуль хөгжүүлэлтийн баталгаа, программ хангамжийн засвар, үйлчилгээг нэг жил хариуцна.

8. Ажил гүйцэтгэх хуваарь

№	Бүтээгдэхүүн	Гэрээ зурснаас хойших хугацаа
1	Эхлэлтийн тайлан /программ хөгжүүлэлт, тестийн/	Гэрээ байгуулснаас хойш 60 хоногийн дотор
2	Эцсийн тайлан /Программ хангамжийн хэрэглэгчийн гарын авлага, сургалтын материал, сургалтын хөтөлбөр, зохион байгуулалт, тайлан/	Гэрээ байгуулснаас хойш 120 хоногийн дотор
Нийт хугацаа		120 хоног